

САР ХАРИУЦСАН АЛБА, ТАСАГ НЭГЖИЙН 2026 ОНЫ 7-Р САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026.08.05

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хувь
1	Үндэсний их баяр наадмын 7 сарын 16-17-ны өдрөөр ажиллах эсэх талаар нийт ажилчдаас санал авч, шийдвэр гаргах	МУЗГ-ын 2026.06.24 өдрийн “Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай” тогтоолоор 2026 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Пүрэв, Баасан гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2026 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг даалгасан бөгөөд эрүүл мэндийн салбар нь баяр наадмын үеэр ачаалал ихэсдэг онцгой салбар тул НЭ-ийн удирдагын шийдвэрээр нийт албан хаагчдаас Үндэсний их баяр наадмын 7 сарын 16-17-ны өдрөөр ажиллах санал авахад 85%-иар дэмжигдсэн. 7 сарын 16-17 өдрүүдэд Амбулаторийн нийт үзлэг 1060 хүнд хийсэн. Үүнээс арьс-29, дотоод шүүрэл -4, мэс засал-91, зүрх судас-27, мэдрэл-30, нүд-74, гэмтэл-108, сэргээн засах-41, хүүхэд-83, няхрай-6, чих хамар хоолой-95, эмэгтэйчүүд-158, эрүү нүүр-31, шүд-30, , хавдар-49, халдварт-27, дотор-111, сэтгэц-12, сүрьеэ12, гемодиализ-38, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ-4	100%
2	Баяр наадмын амралтын өдрүүдээр ажиллах журам гаргаж танилцуулах, хяналт хийх	Үндэсний их баяр наадмын өдрүүдэд эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бэлэн байдлыг хангах тухай НЭ-ийн Захирлын А/111 дүгээр тушаал гарсан. Тушаалын дагуу бүх нийтийн амралтын үеэр ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь, бэлэн байдлыг хангаж дуудагдаж ажилтны хуваариудыг гаргаж ажилтнуудад танилцуулсан. Хариуцлагатай жижээрийн мэдээг тухай бүр ЭМГ-т мэдээлж ажилласан. НЭ-ийн нийгмийн сүлжээний хуудаст ажиллахөдөлр, цагийн мэдээллийг нийтэлсэн.	100%
3	НЭ-ийн гадна талбайн цэвэрлэгээг зохион байгуулах	2026.07.03 өдөр НЭ-ийн гадна талбайн бүх нийтийн цэцэрлэгээг хийсэн Мэргаш 7 сарын 03-ны өдөр сарын эхний Баасан гарагт Бүх нийтийн гадна талбайн цэвэрлэгээг тус нийт алба, тасаг нэгжүүд идэвхитэй хамрагдаж хуваарьт орчноо цэвэрлэхэд бэлтгэлээ хангана уу. /малгай, бээлий, намхан утгай гутал, багаж хэрэгсэл, уут шуудай г.м/ Цэвэрлэгээнд хяналт тавих: 7 дугаар сар хариуцсан нэгжүүд Мэс засал, МЭЗ, Хөнгөвчлөх	100%
4	Шинэ сувилагчийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах	Сувилахуйн албанаас “Шинэ ажилтныг сургах үүрэг” сэдвээр ахлах сувилагч нартай хэлэлцүүлэг хийв. Шинэ төгссөн болон шинээр ажилд орсон сувилагч нарыг ажлын байран дээр богино хугацаанд дасан зохицуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлыг хангахад ахлах сувилагчийн манлайлал, үүрэг оролцоог тодорхойлох, тулгарч буй асуудлыг хэлэлцэх, шийдэл олоход чиглэгдсэн. Хамрагдсан ахлах сувилагч 15	100%

			
5	“Үйлчлүүлэгчийг дэмжих баг” зохион байгуулах, хэлэлцүүлэг хийх	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд СА-ны дэргэд “Үйлчлүүлэгчийг дэмжих баг” (Patient support team)–ыг зохион байгуулж ажиллуулах хэрэгцээ шаардлага, багийн бүрдэлхүүнийг сонгох талаар ахлах сувилагч нартай хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хамрагдсан ахлах сувилагч 15 	100%
6	НЭ-ийн хэмжээнд дотоод их цэвэрлэгээг хийх	2026.07.23 өдөр ХНСХА, СХА, МЭЭ тасаг, Мэс заслын тасгаас зохион байгуулалт хийж НЭ-ийн хэмжээнд бүх ажилтан албан хаагч орчны дотоод их цэвэрлэгээг хийсэн.	100%

			
7	“Гепататын халдвараас сэргийлэх өдөр”-ийн мэдээлэл сургалт суртчилгааны ажил зохион байгуулах	2026.07.29 өдөр дэлхийн Вируст гепатиттай тэмцэх өдрөөр “Гепатит: саад бэрхшээлийг хамтдаа арилгаж, шийдье” уриатайгаар Халдвартын тасгаас үйлчлүүлэгчдэд өдөрлөг зохион байгуулсан. Хамрагдсан 76	100%

2026 оны 07 дугаар сар хариуцсан тасгууд НЭ-ийн алба тасаг нэгжтэй хамтран 7 ажил төлөвлөж бүрэн хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь 100%

Тайлагнасан: Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасаг, Мэс заслын тасаг